



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-11</i>

<i>1. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>6-11</i>
---	-------------

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 07 дугаар сарын 06-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Д.Өнөрболор, С.Чинзориг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрам.

Нэг. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Пүрэвсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин санал хэлэв.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 1.4 дэх дэд заалтын “20 сая тонн хүртэлх” гэснийг “20.0 сая тонноос доошгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Тогтоолын төслийн 1.4 дэх дэд заалтын “20 сая тонн хүртэлх” гэснийг “20.0 сая тонноос доошгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан Зорилт 1.2-г тусгагдсан үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн **1 дэх заалтыг** доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн **1.3 дахь дэд заалтын** “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн” гэснийг “зураг төслийн” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн **1.4 дэх дэд заалтын** “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “өртөө” гэснийг “боомт” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Цэрэнпунцаг: 1.Төслийн 1.1 дэх дэд заалтын “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэснийг “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэж, 1.7 дахь дэд заалтын “Энэ заалтын 3, 4-т” гэснийг “Энэ тогтоолын 1 дэх заалтын 3, 4 дэх дэд заалтад” гэж, 2 дахь заалтын “хорооны хуралдаанд” гэснийг “хороонд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр,
Даваа Төрийн ордон “Их эзэн Чингис
хаан” танхим 11 цаг 32 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр,
Пүрэв Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 35 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Ирц Цэдэндамбын Цэрэнпунцаг ирсэн, Дамбын Батлут гишүүн ирсэн, Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн, Жамбалын Ганбаатар гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Хассуурийн Ганхуяг гишүүн ирсэн, Тогмидын Доржханд гишүүн ирсэн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирсэн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн ирсэн, Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн, Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрэлдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг.

Монгол Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуун сухайт, Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зариг зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Нэн яаралтай гэсэн нэг асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал.

1. “Монгол Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуун сухайт, Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулах уу? Ажлын хэсэг ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Ажлын хэсгийн нэрс хаа байна аа? Нямбаатар сайд Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, Итгэлт Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга, Пүрэвсүрэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуулт асууж дууслаа.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна Энхтүвшин гишүүн байна уу? Энхтүвшин гишүүний микрофоныг нээе. Саналаа хэлье.

Т.Энхтүвшин: Би нэг санал оруулсан юм зүгээр.

Тогтоолын төслийн нэгийн дөр 1.4 дэх заалтад 20 сая тонн хүртэлх гэснийг 20 саяас доошгүй гэж өөрчлөх тийм санал өгч байгаа юм.

Тийм тэгээд энэ 20 сая тонн хүртэл гэхээр аягүй бол 5 сая ч байж болно 10 ч байж болно ингээд байна шүү дээ. Тэгэхээр цаад газартайгаа одоо юу гэж хэлсэн юм. Нэгэнт л одоо 20 сая тонныг нийлүүлнэ гэсэн бол 20 саяас доошгүй гэдэг энэ саналыг нь бас оруулаад явах нь зөв болов уу гэсэн ийм байдлаар л энэ зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Тайлбар өгөх үү эсвэл шууд одоо Энхтүвшин гишүүний оруулж байгаа энэ томъёоллоор санал хураалт явуулчих уу?

Нямбаатар сайдын микрофоныг нээе дээ.

Х.Нямбаатар: Баярлалаа. Яах вэ Энхтүвшин гишүүний хэлж байгаа санаа их чухал санаа л даа. Энэ нөгөө Хүрэлбаатар сайд бид хэд нөгөө юун дээр үлдээд, Бямбацогт сайд, Ганбат захирал бид хэд үлдээд ярилцахдаа нэг зүйл протоколдсон юм. Тэнд бас жижигхэн протокол хөтөлсөн юм. Тэр нь юу вэ гэхээр одоо манай авч байгаа манайхаас авч байгаа БНХАУ-ын нүүрсний квотод Чайна Энержигийн авах квотыг орохгүй байя гэдэг талаар тохирсон юм. Тэгэхээр эдийн засгийн өсөлт юмаа бодох юм бол хориос дээш нийлүүлэх гэдэг Энхтүвшин сайдын санал гишүүний хэлж байгаа саналыг авах нь зөв байх гэж бодож байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид нар бас юугаа харлаа. Нөгөө ерөнхий хэлэлцээр байна шүү дээ. Өнгөрсөн жилийн 8 сард байгуулсан ерөнхий хэлэлцээр дээр 20 сая гээд дээшээ доошоо хэмжээ заагаагүйгээр биччихсэн юм байна. Өөрөөр хэлбэл тэр ерөнхий хэлэлцээр маань бас нэг талдаа ууттай. Дээшээгээ ч байж болохоор агуулгатай юм байна.

Гуравдугаарт нь юу асуух гэж байна вэ гэвэл Байнгын хороон дээр редакцын шинжтэй зарим засварууд байгаа бол Байнгын хороо дахиж нэг хуралдах юм бол Энхтүвшин гишүүний гаргасан саналаар санал хураах нь зарчмын хувьд ялгаагүй хураах нь зөв байх гэж бодож байна.

Хэрвээ хураахгүй ингээд цагаа хожоод яаруу явъя анхных нь хэлэлцүүлгээр баталъя гэж байгаа бол энийг дараа нь одоо энэ тогтоолыг засах асуудал яригдах л байх.

Ц.Цэрэнпунцаг: Нямбаатар сайд сая бас тодорхой тайлбарлалаа. Ер нь энийгээ бас дахиад Байнгын хороон дээр эцсийн хэлэлцүүлэг хийчихье гээд бас бид нар ярилцаад байна. Яагаад вэ гэхээр зөвхөн энэ асуудал биш бусад найруулгын шинж чанартай асуудлууд найруулгын одоо өөрчлөлтүүд оруулах юмнууд байна. Яагаад гэвэл бас нэг нэр томъёон дээр ингээд тодорхой бас биччихсэн юм. Тэгэхээр зэрэг нэгмөсөн одоо тогтоолынхоо төслийг гүйцэд боловсруулаад ингээд явчихъя. Ингээд эцсийн хэлэлцүүлгийг хийчихье. Маргааш бас чуулганы дундуур орж ирээд хуралдсан ч болох юм байна гэж бодсон.

Тэгвэл ингээд саяын Энхтүвшин гишүүний гаргасан саналын томъёоллоор нэгдүгээрт санал хураалт явуулъя. Энэ дээр бас нэмээд хэлчихэд ер нь ингэж ойлгосон шүү дээ Нямбаатар сайдаа.

Дээрээс нь энэ цаад талдаа Чайна Энержийг нь авъя гэж байгаа энэ 20 сая тонн гээд байгаа, яриад байгаа энэ нүүрс

чинь гол нь бас эрчим хүчний нүүрс өнөө мэдлэг эд нар бүгд байгаа юм байна лээ шүү дээ. Эд нар чинь цахилгаан станц барьчхаад одоо энийгээ бас нэмүү ахиухан авъя. Манай нөгөө наад талдаа нөгөө сорчилж аваад байгаа энэ асуудлууд дээр бас нааштай үр дүн гаргаад нөгөө нүүрсний гологдож хаягддаг энэ эрчим хүчний нүүрс нь бага ачигддаг юм уу бас энэ дээр эерэг нөлөөтэй юм болов уу л гэж хараад байна.

Ингээд би саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гацуун сухайт, Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн 1.4 дэх заалтын 20 сая тонн хүртэлх гэснийг 20 сая саяас доошгүй гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин.

Сая тонноос доошгүй. Тонн гэдгээ бичээрэй. Ингээд энэ дээр тийм 20 сая тонноос доошгүй гэж протокол дээрээ бичээрэй. Ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Баттөмөр гишүүн таны наад төхөөрөмж чинь ажилласангүй. Дахиад та ирцэндээ дахиад картаа сугалж байгаад орчих.

Тэгвэл Хүрэлбаатар гишүүн горимын санал гаргая. Үгүй ээ яг сая бол санал өгөх гэж байхад та байж байгаарай гэж хэлсэн. Тэгэхээр би дараагүй байхгүй юу.

Тэгэхээр одоо яана гэсэн үг юм. Хүчингүй болгох санал хураалт явуулж өгөөч.

Хүрэлбаатар сайдын гаргасан саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд саяын санал хураалт дэмжигдэж саяын хураасан санал хураалт хүчингүй болсон учраас дахиж санал хураалтаа явуулъя.

Түрүүн уншсан саналын томъёоллоор санал хураалт.

Дараагийнх нь аль байгаа юм нэг гээд унших юм уу дахиад гишүүдийн 70 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд энэ найруулгын шинж чанартай 4 санал хураалт явуулна. 5 санал хураалт байгаа юм байна. Энийгээ би ингээд эхнээс нь явуулчихъя.

Нэг одоо хүлээж байгаарай. Одоохон биш ээ.

1.Төслийн тэмдэглэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан Зорилт 1.2-т тусгагдсан үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж саяын найруулгын санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1.3 дахь дэд заалтын “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн” гэснийг “зураг төслийн” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

4.Төслийн 1.4 дэх дэд заалтын “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “өртөө” гэснийг “боомт”

гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжигдэж, санал дэмжигдлээ.

5.Найруулгын санал:

Төслийн 1.1 дэх дэд заалтын “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэснийг “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэж, 1.7 дахь дэд заалтын “Энэ заалтын 3, 4-т” гэснийг “Энэ тогтоолын 1 дэх заалтын 3, 4 дэх дэд заалтад” гэж, 2 дахь заалтын “хорооны хуралдаанд” гэснийг “хороонд” гэж тус тус өөрчлөх.

Найруулгын санал төслийн 1.1 дэх заалтын БНМАУ БНХАУ-ын хооронд 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээрт гэснийг 1955 оны Монгол Хятадын төмөр замын хэлэлцээрт гэж 1.7 дахь дэд заалтын энэ заалтын 3 4 дэх гэснийг энэ тогтоолын нэг дэх заалтын 3. 4 дэх дэд заалтад гэж 2 дахь заалтын хорооны хуралдаанд гэснийг хороонд гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг.

Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Нямбаатар сайдын микрофоныг нээж өгье.

Х.Нямбаатар: Би протоколд энэ нөгөө Эдийн засгийн байнгын хороо,

мэргэжлийн Байнгын хороо хуралдаж байгаа учраас 2 зүйл протоколд үлдээмээр байгаа юм.

Нэгдүгээрт энэ тогтоолын төслийн 1.6 дээр ордыг иж бүрнээр нь ашиглаж одоо нөгөө олборлолтынхоо хэмжээг нэмэгдүүлэх тухай заалт орсон юм. Тэгэхээр энэ бол одоогийн байгаа Эрдэнэс Тавантолгой компанийн яг одоогийн хүчин чадлаар бол бид нар 20 дээр нэмэх нь дээшээ хүчин чадлаар. Одоо энэ гэрээлэгч талдаа нийлүүлж чадахгүй. Тийм учраас энэ үндсэн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд одоо энэ ордыг шинээр одоо нөгөө бусад бүлэг ордууд дээр нь уурхайн амууд нээх агуулгатай ийм зохицуулалт ерөнхий хэлэлцээрийн дагуу орж байгаа шүү гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт би протоколд юу гэж нэмж тэмдэглүүлэх гэж байна гэхээр одоо Түвшинжаргал хариулах ёстой. Энэ 8 сард Засгийн газрын хоорондын Хүрлээ сайд ахлах болов уу? Хятадын талаас нөгөө Хөгжил шинэтгэлийн хорооноос энэ компаниудын төлөөлөлтэй нарийвчилсан нөгөө худалдааны хэлэлцээрүүд хийгдэнэ. Ингээд ирэхээр энэ гэрээний хэрэгжилт хэзээнээс хэрэгжих вэ гэхээр ирэх оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд жил болгон одоогийн байгаа хүчин чадлаасаа гадна 5 саяыг айлын талд зарах болж байгаа юм.

Тэгээд 1.6 жил 5, 6 саяар зарж байгаад яг төмөр зам ашиглалтад ороод ингээд 2 талдаа нэвтэрч өнгөрдөг болоод ирэнгүүт нөгөө 20 сая түүнээс дээших болж байгаа юм.

Тэгэхээр худалдан авагч тал нь бэлэн байгаа. Бид нарт шалтгаалах зүйл юу вэ гэвэл энэ уурхайн өөрийнх нь потенциал хүчин чадлыг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ гэдгээ л эднийхэн одоо ажиллах ёстой шүү. Би Түвшинжаргалыг бас протоколд Засгийн газар гэрээ хийчихдэг. 5 саяыг одоо зарж чадах уу? Ирэх жил шууд зараад эхэлнэ шүү дээ.

Одоогийн байгаа зарж байгаа 30 хэдэн саяас чинь гадна.

Ц.Цэрэнпунцаг: Түвшинжаргал даргаас асуучихъя. Сая Нямбаатар сайдын хэлж байгаатай холбогдуулаад одоо бас анхаарах ёстой зүйл байх. Бид нар чинь баахан үүрэг хүлээгээд тийм ээ заавал нэг хүчин чадал гаргах хүчин чадал хүрэлцэхгүй бол яах юм бэ? Энэ дээр бас одоо ямар төлөвлөгөө тэгээд ямар хөрөнгө оруулалт шаардлагатай яг юуг төлөвлөж харж байгаа юм гээд тодорхой хариулчхаарай. Протоколд үлдэнэ шүү. 3 номер ажлын хэсгийн 3 номер.

Э.Түвшинжаргал: Сайдын асуултад хариулъя.

Эрдэнэс Тавантолгой Түвшинжаргал. Яг энэ тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсэг дээр бол энэ асуудал бол хөндөгдөж яригдсан. Уурхай дээр одоо шинээр уурхайн ам буюу уурхайг нээж байж энэ уурхайн одоо хүчин чадлыг нэмэгдүүлэхийг ажлын хэсэг дээр бол яригдаад одоо энэ төслийн тогтоолын 1.6 дахь заалт дээр Таван толгойн ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж гэдэг энэ санаагаар орсон. Хэрвээ яах вэ тодотгоод юу яавал шинээр ордыг нээн нэмэгдүүлж ашиглах гэдэг үгээр орчихвол энэ санаа бол суугаад явна гэж бид бол ярилцсан.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн үг хэлье.

Т.Энхтүвшин: Энэ 1.6 дээр л яриад байх шиг байна л даа. Тэгээд энэ Тавантолгойн бүр бүлэг орд дээр чинь шинээр дахиад ам нээх юм байна шүү дээ Цэрэнпунцаг дарга. Шинээр одоо орд нээх юм байна шүү дээ. Дахиад Тавантолгойн бүлэг орд дээрээ ам нээх юм байна. Дахиад ам нээх юм байна. Тэгэхээр тэр шинээр одоо нээгдэх тэр амынх нь асуудлыг нь бас энэ дээрээ тусгаад явбал яасан юм. Энэ ашиглах, олборлох, тээвэрлэх,

экспортыг нэмэгдүүлэх, шинээр одоо орд нээх гэдэг үгийг нь.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Монгол Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуун сухайт, Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын

тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Ингээд хуралдаанд идэвхтэй идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

14:57

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА